



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 1/98

Номгон

Орон нутаг дахь “Хүний эрхийг хангах,
хамгаалах” тайлагнах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлах тухай Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1, Засгийн газрын 2023 оны “Ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 357 дугаар тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн хэмжээний Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах, хамгаалах, орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах ажлын дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Жендэрийн эрх тэгш байдал, орон нутгийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Өмгөөлөгчдийн зөвлөлийн төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Иргэний нийгмийн төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга


2.Хүний эрхийг хангах хамгаалах зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жил бүр төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган арга хэмжээг үр

625010281

W:\2025 ON\Zakhiramj\Захирамж+++.docx

дүнтэй зохион байгуулж Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН